



Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248
дугаарын утаснаас лавлана уу?
Л.Жаргалсайхан
Аймгийн Тэргүүлэх аудитор
өрөөний утас 70272582

О.Амаржаргал- Аудитор
өрөөний утас 70273463

Аймгийн Аудитын газар
Төрийн байгууллагын ордон

БАРУУН ЗУУНМОД ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

2013 оны Санхүүгийн Тайлан

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

- СТ-ийн аудит дууссан мэдэгдэл.....
- Танилцуулга
- Гол шийдлүүд
- Залруулагдаагүй алдаа
- Тайлбар мэдүүлгийн захидал.....
- Аудитын санал дүгнэлт
- Аудитлагдсан Санхүүгийн байдлын тайлан.....
- Аудитлагдсан Санхүүгийн үр дүнгийн тайлан.....
- Аудитлагдсан Мөнгөн гүйлгээний тайлан.....
- Аудитлагдсан Өмчийн өөрчлөлтийн тайлан.....
- Аудитлагдсан Төсвийн гүйцэтгэлийн тайлан.....

**Баруун Зуунмод өрхийн эрүүл мэндийн төвийн
2013 оны Санхүүгийн тайланд
ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Баруун Зуунмод өрхийн эрүүл мэндийн төвийн 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дууссан ба өрхийн эмнэлгийн төсвийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Баруун Зуунмод өрхийн эрүүл мэндийн төв тухайн зөвлөмж бүрд хариу ирүүлнэ үү.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна.

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг тодруулбал:

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг торуулвал:

- Төсвийн хуваарийг 8077 хүн амд үйлчлэх 109593,7 мянган төгрөгөөр сар сард нь зардлын зүйлээр хувиарлаж 2013.01.04-ны өдөр баталсан байснаа зардлын зүйлүүдийг хооронд нь гүйлгэн дахиж 2013.10.10-нд баталсан байна.
- Төсвийн хөрөнгөөр 4568,0 мянган төгрөгний үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.
- 28710,3 мянган төгрөгний хуримтлагдсан алдагдалтай, 2013 онд 4884,4 мянган төгрөгний алдагдалтай ажилласан байна.

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх зөрчлүүд материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Тэргүүлэх аудиторт санал оруулсан байгаа.

Тэргүүлэх Аудитор 2014.03.24-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ерөнхий нягтлан бодогч Э.Нарантуяа бидэнтэй хамтран бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

**Үндэсний аудитын газрын харьяа
Төв аймгийн Аудитын газар**

2014.03.24

Танилцуулга

1. Бид Баруун Зуунмод өрхийн эрүүл мэндийн төвийн 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусч байна. Өрхийн эмнэлгийн удирдлагад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх

Аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Өрхийн эрүүл мэндийн төвийн хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлагад тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан. Дараах түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлагын анхаарлыг хандуулж байна:

Санхүүгийн дотоод хяналтын талаар

МУ-ын ЗГЗрын 2011.11.09 –ний өдрийн 311-р тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам батлагдсан байна. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам” –ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө гэж заасны дагуу байгууллагад дотоод хяналт шалгалтыг хэрхэн хийж байгаа талаар шалгахад байгууллагын даргын 2013.01.15-ны өдрийн 14 тоот тушаалаар дотоод хяналтын комисс томилогдон ажилладаг бөгөөд материалын худалдан авалт бүр дээр, эм, эмнэлгийн хэрэгсэлийн үлдэгдэлд сар бүр хяналт хийж тайлан бичсэн байна.

Орлого санхүүжилт

2013 онд батлагдсан төлөвлөгөөгөөр 109593,7 мянган төгрөгийн санхүүжилт авахаас гүйцэтгэлээр төсвөөс 109593,9 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Мөнгөн журналаас орлогыг сортлон авч сар бүрийн санхүүжилтийг харилцахын баримттай тулган шалгахад санхүүжилт дүнгээрээ бүрэн тохирч байна.

Бараа үйлчилгээний зардал

Бараа материалын тайлангаас бичигдсэн зардлуудыг баримтаас түүвэрлэн шалгахад няравын тайланд шатахуун болон материалын зардал, үндсэн хөрөнгийн худалдан авалт санхүүгийн үр дүнгийн тайланд зөв тайлагнагдсан байна.

Бараа материал

Эд хариуцагч бараа материалын тайланг хугацаандаа гаргаж хэвшсэн ба бараа материалын тайлан гаргалт, анхан шатны баримтын бүрдэлт хэвийн байна. Санхүүгийн тайланд хөтлөгдөх анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг бүрэн хөтөлж байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 9286,3 мянган төгрөгийн худалдан авалт хийж зөв ангилан холбогдох бараа материалын дансуудад орлого авсан байна. 7171,5 мянган төгрөгийн бараа материал зарлагадан холбогдох зардлын дансуудад бүртгэсэн байна.

Баруун Зуунмод өрхийн эмнэлгийн даргын 2013.12.27-ны өдрийн 48 тоот тушаалаар бараа материалын үлдэгдлийн тооллого хийсэн байна. Тооллогын комиссын хийсэн тооллогын бүртгэлийг няравын тайлантай, бараа материалын орлого зарлагын журналын дүнтэй тулган шалгахад таарч байна. Тооллогоор 9 нэр төрлийн эмнэлгийн багаж хэрэгсэл, 3 нэр төрлийн хангамжийн материал бүртгэлгүй байсныг илрүүлж тайланд тусгуулсан байна. Мөн байгууллагад эдлэгдэж байгаад эвдэрсэн, цаашид ашиглах нөхцөлгүй болсон 41 нэр төрлийн 1585,5 мянган төгрөгний хангамжийн материал, эмнэлгийн багаж хэрэгсэлийг актлуулах санал оруулж даргын тушаалаар шийдвэрлүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө

Баруун Зуунмод өрхийн эрүүл мэндийн төв нь 2013 оны санхүүгийн тайлант жилд 400,0 мянган төгрөгний машин, тоног төхөөрөмж, 4168,0 мянган төгрөгний тавилга эд хогшил худалдаж авч, 11607,4 мянган төгрөгний элдэгдлийг шулуун шугмын аргаар байгуулсан байна.

Баруун Зуунмод өрхийн эрүүл мэндийн төвийн даргын 2013.12.27-ны өдрийн 48 тоот тушаалаар үндсэн хөрөнгийн үлдэгдлийн тооллого хийж тооллогын дүнгээр ямар нэгэн илүү дутуу зөрчил илрээгүй байна. Мөн байгууллагад эдлэгдэж байгаад эвдэрсэн, цаашид ашиглах нөхцөлгүй болсон 5 нэр төрлийн 2474,1 мянган төгрөгний үндсэн хөрөнгийг актлуулах санал аймгийн орон нутгийн өмчийн албанд явуулсан боловч шийдэгдээгүй байна.

Цалин хөлсний талаар

Цалинг олгохдоо өдөр тутмын цагийн бүртгэлээс ажилласан өдрийн тодорхойлолтыг хийж гарын үсэг зурж ерөнхий менежер баталсан цагийн балансаар цалин бичиж хэвшсэн байна. Цалин тогтоолт, бодолт, суутгал хийсэн байдлыг шалгахад ажилтнуудын цалинг Засгийн газраас тогтоосон цалингийн сүлжээний дагуу нөхөрлөлийн гишүүдийн хурлаар тогтоосон байна.

Санхүүгийн тайланд тайлагнасан 67842,3 мянган төгрөгийн цалингийн сан, 16595,7 мянган төгрөгний НДШ нь Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, Татварын хэлтэстэй хийсэн суутгасан албан татварын тайлантай тохирч байна. Бодогдсон цалингаас хуулийн дагуу тооцож суутгасан татвар хураамжийг НББ-ийн журнал, санхүүгийн тоо дүнтэй тулган шалгахад тохирч байна. Цалингийн цэсэнд ажилчдаар гарын үсэг зуруулж хэвшсэн байна.

Авлага, өглөг

НДШ-ийн тооцоо нь НДХэлтэст тайлагнасан тайлан, холбогдох баримтуудыг үндэслэн шалгахад авлага өглөгийн гүйлгээ нь санхүүгийн тайлантай тохирч байгаа бөгөөд тайлант оны эцэст өглөг, авлагагүй гарсан байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн. Эдгээр асуудлуудыг Аймгийн Аудитын газрын болон Баруун Зуунмод өрхийн эрүүл мэндийн төв авч үзэж хангалттайгаар шийдсэн.

Залруулагдаагүй алдаа

Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газрыг аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Тайлант хугацаанд залруулагдаагүй алдаа байхгүй.

Тайлбар мэдүүлгийн захидал

Аудитын үйл явцад ААГ хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ удирдлагаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлт

Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлтийг бүрэн ирүүлсэн байна.

Аудитын санал дүгнэлт

Аймгийн Аудитын газраас тус тайланд зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

**Үндэсний аудитын газрын харьяа
Төв аймгийн Аудитын газар
2014.03.24**